



**МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО**

**ТАНИЛЦУУЛГА:
*ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН,
ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО
2013 ОНД***

2014 оны 9 сар

ГАРЧИГ

Удиртгал

ДНБ-ий 2010-2013 оны гүйцэтгэл

Нэг. Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий гүйцэтгэл

1. ДНБ-ий оны үнийн тооцоо
 - 1.1 ДНБ, салбараар
 - 1.2 Бүс, аймгийн ДНБ-ий тооцоо
2. ДНБ-ий зэрэгцүүлэх үнийн тооцоо

Хоёр. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий гүйцэтгэл

Гурав. Орлогын аргаар тооцсон ДНБ-ий гүйцэтгэл

Дөрөв. Үндэсний нийт орлого

ТАВ. Нэг хүнд ногдох ДНБ, ҮНО

ЗУРГАА. Далд эдийн засаг

Хавсралт 1. ДНБ, оны үнээр, тэрбум төг

Хавсралт 2. ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг

Хавсралт 3. Макро-эдийн засгийн зарим үзүүлэлтүүд

Хавсралт 4. Нэг хүнд ногдох ДНБ, ҮНО

Хавсралт 5. ДНБ, ҮНО, ҮНЭО, оны үнээр, сая төг

Удиртгал

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь улс орны эдийн засгийн үйл ажиллагааны цар хэмжээг харуулдаг макро эдийн засгийн чухал үзүүлэлт юм.

ДНБ-ийг үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын гэсэн 3 аргаар тооцдог. Нийт үйлдвэрлэлтээс завсрын хэрэглээг хасч нэмэгдэл өртгөөр тооцохыг үйлдвэрлэлийн; эцсийн хэрэглээ, хуримтлал, цэвэр экспортын нийлбэрээр тодорхойлохыг эцсийн ашиглалтын; хөдөлмөрийн хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ буюу үндсэн хөрөнгийн элэгдэл, үйлдвэрлэл болон импортын цэвэр татвар, үйл ажиллагааны цэвэр ашиг, холимог орлого зэрэг орлогын элементийн нийлбэрээр тооцохыг орлогын арга гэж нэрлэнэ.

ДНБ-ий үйлдвэрлэлийн аргын тооцоо нь эдийн засгийн үйл ажиллагааны салбараар хийгддэг ба эдгээр эдийн засгийн салбарын үйл ажиллагаа нь ДНБ-д ямар хувь нэмэр оруулж байгааг харуулдаг.

ДНБ-ий эцсийн ашиглалтыг эцсийн хэрэглээ (өрхийн аж ахуйн, өрхийн аж ахуйд үйлчилдэг арилжааны бус байгууллагын, төрийн байгууллагын хэрэглээ), хөрөнгийн нийт хуримтлал (үндсэн хөрөнгийн, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлс), экспорт, импортын үйл ажиллагаа гэсэн үндсэн хүрээ, холбогдох дэд хэсгүүдэд хуваагддаг.

Мөн эдийн засгийн бодит өсөлтийг үнийн өсөлтийн нөлөөллийг арилгасан буюу зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ий өөрчлөлтөөр тодорхойлдог. Эдийн засгийн орчин, салбарын бүтцэд гарах өөрчлөлт нь суурь оныг тодорхой давтамжтай өөрчлөх үндэслэл болдог.

Манай улс өмнө нь ААНБ-ын тооцоонд 1967, 1986, 1993, 1995, 2000, 2005 оныг суурь он болгон ашиглаж байсан. ДНБ-ий зэрэгцүүлэх суурь оныг 2010 оноор шинэчлэхтэй холбоотой дагалдах судалгаа, тооцооллуудыг хийлээ.

ДНБ-ий суурийг шинэчлэхтэй холбогдон хийсэн тооллого, судалгаа:

- Тооллого: ААНТ, ХААТ, ХАОСТ
- Судалгаа, тооцоолол:
 - ДЭЗ-ийн бүрэн хэмжээний судалгаа, тооцоолол
 - Малын ашиг шим, гарцын судалгаа, холбогдох тооцоолол
 - Үйлдвэрлэгчийн үнийн судалгаа, үнийн индексийн тооцоолол

Үндэсний нийт орлого (ҮНО) тухайн улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн шинээр бүтээсэн нийт нэмэгдэл өртгийн дүн байна. ҮНО-ыг ДНБ дээр гадаад эдийн засгаас орж ирсэн цэвэр орлого буюу эдийн засгийн харьяатаас орж ирсэн орлогоос харьяат бусад төлсөн зардлыг хасч тооцоолно.

Гадаад эдийн засгаас орж ирэх орлогод харьяат, харьяат бусын хооронд үйлдвэрлэлийн үйл явцад орц буюу хөдөлмөр нийлүүлэх, санхүүгийн хөрөнгө эзэмших, байгалийн баялгийг түрээслэхтэй холбогдон гарсан ажил, гүйлгээ, түүний орлогыг хамааруулна.

ҮСХ-ны даргын 2013 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 01/134 тоот тушаалаар баталсан “Дотоодын нийт бүтээгдэхүүн болон Үндэсний нийт орлого тооцох аргачлал”-ын дагуу ДНБ-ны тооцоог жил бүр хийж хэрэглэгчдэд тархааж байна.

Танилцуулга нь ДНБ-ий үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын аргаар 2010 оны нөөц ашиглалтын хүснэгтэд тулгуурлан тооцсон үр дүнгүүд, ҮНО, ҮНЭО болон хавсралт (ДНБ-тэй холбоотой макро-эдийн засгийн зарим гол үзүүлэлтүүдийг тусгасан) гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

ДНБ-ий 2013 оны гүйцэтгэл

ДНБ-ий 2013 оны гүйцэтгэлийг үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын аргаар, оны болон 2010 оны зэрэгцүүлэх үнээр, орлогын аргаар оны үнээр тооцсон.

ДНБ, оны үнээр

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ оны үнээр 2013 онд 19118.0 тэрбум төг, эцсийн ашиглалтын аргаарх ДНБ 19326.2 тэрбум төгрөгт хүрч, ДНБ-ий 2 аргын тооцооны зөрүү 1.1 хувь байна.

Хүснэгт 1. ДНБ, оны үнээр

	2010	2011	2012	2013
<i>ДНБ (тэрбум төг.)</i>				
ДНБ (үйлдвэрлэлийн)	9 756.6	13 173.8	16 688.4	19 118.0
ДНБ (эцсийн ашиглалтын)	9 756.6	13 173.8	16 688.4	19 326.2
<i>Өөрчлөлт өмнөх оныхоос (хувиар)</i>				
ДНБ (үйлдвэрлэлийн)		35.0	26.7	14.6
ДНБ (эцсийн ашиглалтын)		35.0	26.7	15.8

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2013 онд 14350.1 тэрбум төг, эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ 14403.5 тэрбум төг болж, өмнөх оныхоос үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ 11.6 хувь, эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ 11.7 хувиар өслөө.

Хүснэгт 2. ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

	2010	2011	2012	2013
<i>ДНБ (тэрбум төг.)</i>				
ДНБ (үйлдвэрлэлийн)	9 756.6	11 443.6	12 853.4	14 350.1
ДНБ (эцсийн ашиглалтын)	9 756.6	11 467.7	12 898.9	14 403.5
<i>Өөрчлөлт өмнөх оныхоос (хувиар)</i>				
ДНБ (үйлдвэрлэлийн)		17.3	12.3	11.6
ДНБ (эцсийн ашиглалтын)		17.5	12.5	11.7

НЭГ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АРГААРХ ДНБ-ИЙ 2013 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

1. ДНБ-ий оны үнийн тооцоо

1.1. ДНБ, салбараар


Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ оны үнээр 2013 онд 19118.0 тэрбум төгрөгт хүрч, 2012 оныхоос 2429.6 тэрбум төгрөг буюу 14.6 хувиар нэмэгдлээ.

Хүснэгт 3. ДНБ, оны үнээр, тэрбум төг.

	2010	2011	2012	2013	$\frac{2013}{2012}$ %
ДНБ	9 756.6	13 173.8	16 688.4	19 118.0	114.6
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1 144.7	1 357.9	1 878.8	2 603.6	138.6
Уул уурхай, олборлолт	2 102.2	2 536.2	2 742.8	2 965.6	108.1
Боловсруулах үйлдвэрлэл	664.8	931.4	1 248.7	1 708.3	136.8
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	190.2	212.4	233.9	270.5	115.6
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	31.2	44.9	72.5	77.5	106.9
Барилга	250.2	402.8	837.5	978.9	116.9
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1 199.0	1 973.3	2 231.1	2 123.9	95.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	677.9	802.9	894.4	835.6	93.4
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	52.6	94.3	186.2	201.6	108.3
Мэдээлэл, холбоо	255.7	290.3	379.6	402.4	106.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	239.6	381.1	583.5	797.5	136.7
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	687.7	884.2	957.3	1069.9	111.8
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	132.3	216.2	424.2	437.6	103.2
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	81.1	71.2	177.6	193.2	108.8
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	425.4	515.3	699.1	788.8	112.8
Боловсрол	379.9	503.1	744.9	854.5	114.7
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	167.2	193.2	316.9	359.1	113.3
Урлаг, үзвэр, тоглоом наадам	32.0	39.5	87.0	84.1	96.7
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	44.4	67.2	137.8	145.0	105.2
Бүтээгдэхүүний цэвэр татвар	998.4	1 656.3	1 854.4	2 220.1	119.7

2013 онд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 38.6 хувь, үйлдвэрлэлийн салбарынх 20.2 хувь, үйлчилгээний салбарынх 35.7 хувь, бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ 19.7 хувиар өмнөх оныхоос нэмэгдсэн байна.

Зураг 1. ДНБ, салбарын бүтэц, хувиар



2013 онд үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувийн жин хамгийн өндөр буюу 43.4 хувь байсан байна. Энэ нь өмнөх оныхтой харьцуулахад 3.5 пунктээр буурсан байна. Үйлдвэрлэлийн салбарын хувьд 2013 онд нийт ДНБ-ий гуравны нэгийг бий болгож байна. Хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь өмнөх оныхоос 2.3 пунктээр нэмэгджээ.

Хүснэгт 4. ДНБ-ий салбарын бүтэц, хувиар

	2010	2011	2012	2013
ДНБ	100.0	100.0	100.0	100.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	11.7	10.3	11.3	13.6
Уул уурхай, олборлолт	21.5	19.3	16.4	15.5
Боловсруулах үйлдвэрлэл	6.8	7.1	7.5	8.9
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1.9	1.6	1.4	1.4
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа	0.3	0.3	0.4	0.4
Барилга	2.6	3.1	5.0	5.1
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	12.3	15.0	13.4	11.1
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	6.9	6.1	5.4	4.4
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	0.5	0.7	1.1	1.1
Мэдээлэл, холбоо	2.6	2.2	2.3	2.1
Санхүү, даатгалын үйл ажиллагаа	2.5	2.9	3.5	4.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	7.0	6.7	5.7	5.6
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.4	1.6	2.5	2.3
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.8	0.5	1.1	1.0
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	4.4	3.9	4.2	4.1
Боловсрол	3.9	3.8	4.5	4.5
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1.7	1.5	1.9	1.9
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.3	0.3	0.5	0.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.5	0.5	0.8	0.8
Бүтээгдэхүүний цэвэр татвар	10.2	12.6	11.1	11.6


1.2 Бүс, аймгийн ДНБ-ий гүйцэтгэл

Бүсийн ДНБ-ий (оны үнээрх) 2013 оны гүйцэтгэлийг 2012 оныхтой харьцуулбал баруун бүсийнх 30.2 хувь, хангайн бүсийнх 14.5 хувь, төвийн бүсийнх 22.7 хувь, зүүн бүсийнх 35.0 хувь, Улаанбаатарынх 10.8 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 5. ДНБ, бүс, аймгаар, оны үнээр, тэрбум төг

	2010	2011	2012	2013	<u>2013%</u> 2012
ДНБ	9 756.6	13 173.8	16 688.4	19 118.0	114.6
Баруун бүс	493.7	656.4	860.4	1 120.3	130.2
Баян-Өлгий	108.3	143.2	179.6	225.5	125.5
Говь-Алтай	66.0	89.2	125.8	159.4	126.7
Завхан	100.2	137.2	192.3	248.0	129.0
Увс	106.1	145.1	183.0	232.9	127.3
Ховд	113.2	141.8	179.7	254.5	141.6
Хангайн бүс	1 535.2	1 902.5	2 269.0	2 598.4	114.5
Архангай	120.1	175.0	252.5	294.1	116.5
Баянхонгор	105.4	145.4	193.8	254.1	131.1
Булган	131.3	158.8	188.2	249.3	132.5
Орхон	882.6	1 043.8	1 138.0	1 141.1	100.3
Өвөрхангай	103.8	148.3	206.9	291.9	141.1
Хөвсгөл	192.1	231.1	289.7	367.9	127.0
Төвийн бүс	1 179.7	1 427.2	1 744.7	2 140.1	122.7
Говьсүмбэр	29.4	34.4	40.5	56.1	138.8
Дархан-Уул	163.8	192.3	258.1	303.5	117.6
Дорноговь	106.0	173.5	237.4	269.8	113.6
Дундговь	69.5	88.8	121.5	174.9	143.9
Өмнөговь	238.7	361.9	364.6	452.6	124.1
Сэлэнгэ	395.2	361.9	444.3	511.6	115.1
Төв	177.2	214.4	278.3	371.7	133.6
Зүүн бүс	394.0	545.2	688.0	929.0	135.0
Дорнод	139.3	208.6	247.3	382.0	154.5
Сүхбаатар	143.2	178.6	234.2	272.2	116.2
Хэнтий	111.5	158.0	206.5	274.8	133.1
Улаанбаатар	6 153.9	8 642.5	11 126.3	12 330.3	110.8

Зураг 2. Бүсийн ДНБ (оны үнээрх)-ий өсөлт, хувиар



ДНБ-д эзлэх хувийн жин 2013 онд 2012 оныхтой харьцуулахад баруун болон төвийн бүсийнх 0.7 пунктээр, зүүн бүсийнх 0.8 пунктээр нэмэгдсэн ба харин Улаанбаатарынх 2.2 пунктээр буурсан байна.

Хүснэгт 6. ДНБ-д бүс, аймгийн эзлэх хувийн жин

	2010	2011	2012	2013
ДНБ	100.0	100.0	100.0	100.0
Баруун бүс	5.1	5.0	5.2	5.9
Баян-Өлгий	1.1	1.1	1.1	1.2
Говь-Алтай	0.7	0.7	0.8	0.8
Завхан	1.0	1.0	1.2	1.3
Увс	1.1	1.1	1.1	1.2
Ховд	1.2	1.1	1.1	1.3
Хангайн бүс	15.7	14.4	13.6	13.6
Архангай	1.2	1.3	1.5	1.5
Баянхонгор	1.1	1.1	1.2	1.3
Булган	1.3	1.2	1.1	1.3
Орхон	9.0	7.9	6.8	6.0
Өвөрхангай	1.1	1.1	1.2	1.5
Хөвсгөл	2.0	1.8	1.7	1.9
Төвийн бүс	12.1	10.8	10.5	11.2
Говьсүмбэр	0.3	0.3	0.2	0.3
Дархан-Уул	1.7	1.5	1.5	1.6
Дорноговь	1.1	1.3	1.4	1.4
Дундговь	0.7	0.7	0.7	0.9
Өмнөговь	2.4	2.7	2.2	2.4
Сэлэнгэ	4.1	2.7	2.7	2.7
Төв	1.8	1.6	1.7	1.9
Зүүн бүс	4.0	4.1	4.1	4.9
Дорнод	1.4	1.6	1.5	2.0
Сүхбаатар	1.5	1.4	1.4	1.4
Хэнтий	1.1	1.2	1.2	1.4
Улаанбаатар	63.1	65.6	66.7	64.5

Хүснэгт 7. Эдийн засгийн үйл ажиллагаа, салбараар, 2013

	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар	Дүн
Хөдөө аж ахуй	20.5	31.7	28.1	14.0	5.7	100.0
Аж үйлдвэр, барилга	2.0	17.9	11.7	5.4	63.1	100.0
Худалдаа, зочид буудал, зоогийн газар	2.9	3.6	3.4	0.9	89.3	100.0
Тээвэр, мэдээлэл, холбоо	3.3	3.6	6.7	0.7	85.6	100.0
Санхүү, бизнесийн бусад үйл ажиллагаа	3.0	4.9	6.2	1.9	84.0	100.0
Бусад үйлчилгээ	9.4	11.1	10.8	4.6	64.1	100.0

2. ДНБ-ий зэрэгцүүлэх үнийн тооцоо

ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2013 оны гүйцэтгэлээр 11.6 хувиар өсч, 14350.1 тэрбум төгрөгт хүрлээ.

Хүснэгт 8. ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг.

	2010	2011	2012	2013	$\frac{2013}{2012} \%$
ДНБ	9 756.6	11 443.6	12 853.4	14 350.1	111.6
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1 144.7	1 141.1	1 381.3	1 647.9	119.3
Уул уурхай, олборлолт	2 102.2	2 263.7	2 452.2	2 927.4	119.4
Боловсруулах үйлдвэрлэл	664.8	717.1	779.7	864.7	110.9
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	190.2	203.1	213.2	224.8	105.4
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	31.2	31.9	31.5	32.6	103.5
Барилга	250.2	307.0	568.8	615.2	108.2
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1 199.0	1 755.4	1 965.6	2 093.5	106.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	677.9	779.9	843.2	828.5	98.3
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	52.6	66.7	75.8	80.5	106.2
Мэдээлэл, холбоо	255.7	270.5	314.3	355.8	113.2
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	239.6	357.4	509.0	677.3	133.1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	687.7	704.0	718.0	733.4	102.1
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	132.3	133.8	135.3	141.9	104.9
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	81.1	82.6	84.3	83.9	99.5
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	425.4	387.5	408.0	429.1	105.2
Боловсрол	379.9	383.0	387.3	392.4	101.3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	167.2	151.6	154.9	162.9	105.2
Урлаг, үзвэр, тоглоом наадам	32.0	28.3	28.9	30.3	104.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	44.4	52.4	57.6	57.8	100.3
Бүтээгдэхүүний цэвэр татвар	998.4	1 626.5	1 744.4	1 970.2	112.9

ДНБ өмнөх оныхоос 11.6 хувь өсөхөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 266.6 тэрбум төг буюу 19.3 хувь, уул уурхай, олборлох салбар 475.2 тэрбум төг буюу 19.4 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 85.0 тэрбум төг буюу 10.9 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбар 127.9 тэрбум төг буюу 6.5 хувь, барилгын салбар 46.4 тэрбум төг буюу 8.2 хувь, санхүү, даатгалын салбар 168.3 тэрбум төг буюу 33.1 хувь өссөн нь голлон нөлөөлжээ.

ХОЁР. ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААР ТООЦСОН ДНБ-ИЙ ГҮЙЦЭТГЭЛ


2.1 ДНБ-ий оны үнийн тооцоо

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ 2013 онд оны үнээр 19326.2 тэрбум төг болж, өмнөх оныхоос 2637.8 тэрбум төг буюу 15.8 хувиар өслөө.

Хүснэгт 9. ДНБ, оны үнээр, тэрбум төг.

	2010	2011	2012	2013	<u>2012%</u> 2011	<u>2013%</u> 2012
ДНБ	9 756.6	13 173.8	16 688.4	19 326.2	126.7	115.8
Эцсийн хэрэглээ	6 625.2	8 397.1	11 105.4	13 174.4	132.3	118.6
Хөрөнгийн нийт хуримтлал	4 106.3	7 660.3	9 328.6	10 055.1	121.8	107.8
Цэвэр экспорт	- 974.9	- 2 883.7	- 3 745.6	- 3 903.3	-	-

Зураг 3. ДНБ, оны үнээр, тэрбум төг.



Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ 15.8 хувиар өсөхөд эцсийн хэрэглээ 2069.0 тэрбум төг буюу 18.6 хувиар, хөрөнгийн нийт хуримтлал 726.5 тэрбум төг буюу 7.8 хувиар өссөн нь голлон нөлөөллөө.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий 2013 оны бүтцийг авч үзвэл эцсийн хэрэглээ 68.2 хувь, хөрөнгийн нийт хуримтлал 52.0 хувь, цэвэр экспорт (-20.2) хувь болж, өмнөх оныхоос эцсийн хэрэглээ 1.7 пункт, цэвэр экспорт 2.2 пунктээр тус тус өсч, хөрөнгийн нийт хуримтлал 3.9 пунктээр буурсан байна.


Хүснэгт 10. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ-ий бүтэц, оны үнээр, хувиар

	2010	2011	2012	2013
ДНБ	100.0	100.0	100.0	100.0
Эцсийн хэрэглээ	67.9	63.7	66.5	68.2
өрхийн аж ахуйн хэрэглээ	54.6	50.9	52.5	54.4
төрийн байгууллагын хэрэглээ	12.7	12.3	13.5	13.4
төрийн бус байгууллагын хэрэглээ	0.6	0.6	0.5	0.4
Хөрөнгийн нийт хуримтлал	42.1	58.1	55.9	52.0
үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	34.5	48.4	45.1	39.5
материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт болон үнэт зүйлсийн хуримтлал	7.6	9.7	10.8	12.5
Цэвэр экспорт	- 10.0	- 21.9	- 22.4	- 20.2
бараа, үйлчилгээний экспорт	46.7	52.6	43.6	39.6
бараа, үйлчилгээний импорт	56.7	74.4	66.0	59.8

Эцсийн хэрэглээ


Эцсийн хэрэглээ 2013 онд 13174.4 тэрбум төг болж, өмнөх оныхоос 2069.0 тэрбум төг буюу 18.6 хувиар өслөө. Эцсийн хэрэглээний ДНБ-д эзлэх хувийн жин 2013 онд 68.2 хувь болж өмнөх оныхоос 1.7 пунктээр өссөн байна.

Зураг 4. ДНБ-ий эцсийн ашиглалтын бүтэц, оны үнээр, хувиар




Өрхийн аж ахуйн хэрэглээ 2011 онд 25.9 хувь, 2012 онд 30.7 хувь, 2013 онд 19.9 хувиар тус тус өссөн байна.

Зураг 5. Өрхийн хүнсний болон хүнсний бус хэрэглээ, тэрбум төг



Зураг 6. Өрхийн эцсийн хэрэглээний өсөлт, хувиар



Өрхийн аж ахуйн эцсийн хэрэглээний нийт зардал дотор өрхийн хүнсний хэрэглээний зардал 5.2 хувиар, хүнсний бус хэрэглээний зардал 30.1 хувиар тус тус өссөн байна.

Төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ 2013 оны гүйцэтгэлээр 2580.3 тэрбум төг болж, өмнөх оныхоос 322.9 тэрбум төг буюу 14.3 хувиар өссөн байна.

Төрийн бус байгууллагын эцсийн хэрэглээ 2013 оны гүйцэтгэлээр 85.6 тэрбум төг болж, өмнөх оныхоос 3.5 тэрбум төг буюу 4.3 хувиар нэмэгдлээ.

Хүснэгт 11. Хөрөнгийн нийт хуримтлал, тэрбум төг.

	2010	2011	2012	2013	2012% 2011	2013% 2012
Хөрөнгийн нийт хуримтлал	4 106.3	7 660.3	9 328.6	10 055.1	121.8	107.8
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	3 364.7	6 377.7	7 529.2	7 634.5	118.1	101.4
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт болон үнэт зүйлсийн хуримтлал	741.6	1 282.6	1 799.4	2 420.6	140.3	134.5

Үндсэн хөрөнгийн хуримтлалын хэмжээ 2013 оны гүйцэтгэлээр 7634.5 тэрбум төг болж, өмнөх оныхоос 105.3 тэрбум төг буюу 1.4 хувиар өссөн байна.

Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт болон үнэт зүйлсийн хуримтлал 2013 оны гүйцэтгэлээр 2420.6 тэрбум төг болж, өмнөх оныхоос 621.2 тэрбум төг буюу 34.5 хувиар өссөн байна.

Цэвэр экспорт

Бараа, үйлчилгээний экспорт 2013 оны гүйцэтгэлээр 4269.1 сая ам.долл, импорт 6357.8 сая ам.долл болж, өмнөх оныхоос экспорт 115.6 сая ам.долл буюу 2.6 хувь, импорт 380.6 сая ам.долл буюу 5.6 хувиар буурсан.

ДНБ-ийг үндэсний мөнгөн тэмдэгтээр тооцдог учир цэвэр экспортын хэмжээг төгрөг рүү шилжүүлэн тооцоход бараа, үйлчилгээний экспорт 7651.3 тэрбум төг, импорт 11554.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос экспорт 5.2 хувь, импорт 4.9

хувьд өссөн дүнтэй гарлаа. Энэ нь америк долларын төгрөгтэй харьцах ханшийн өсөлттэй холбоотой юм.

Цэвэр экспорт буюу гадаад худалдааны алдагдал 2013 онд 3903.3 тэрбум төг болж, өмнөх оныхоос алдагдал 157.7 тэрбум төг буюу 4.2 хувиар өсчээ.

Хүснэгт 12. Экспорт, импортын хэмжээ, тэрбум төг.

	2010	2011	2012	2013	<u>2012%</u> 2011	<u>2013%</u> 2012
Экспорт	4 554.3	6 923.3	7 271.5	7 651.3	105.0	105.2
бараа	3 932.0	6 150.5	6 014.4	6 571.3	97.8	109.3
үйлчилгээ	622.3	772.8	1 257.1	1 080.0	162.7	85.9
Импорт	5 529.2	9 807.0	11 017.1	11 554.5	112.3	104.9
бараа	4 702.6	8 586.7	9 387.3	9 756.6	109.3	103.9
үйлчилгээ	826.6	1 220.3	1 629.8	1 797.9	133.6	110.3
Цэвэр экспорт	- 974.9	- 2 883.7	- 3 745.6	- 3 903.3	129.9	104.2

2.2 ДНБ-ий зэрэгцүүлэх үнийн тооцоо


Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ 2013 оны гүйцэтгэлээр, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 14403.5 тэрбум төг болж, өмнөх оноос 1504.5 тэрбум төг буюу 11.7 хувиар өслөө.

Хүснэгт 13. ДНБ, зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг.

	2010	2011	2012	2013	<u>2012%</u> 2011	<u>2013%</u> 2012
ДНБ	9 756.6	11 467.7	12 898.9	14 403.5	112.5	111.7
Эцсийн хэрэглээ	6 625.2	7 667.7	8 762.7	10 019.2	114.3	114.3
Хөрөнгийн нийт хуримтлал	4 106.3	6 683.4	7 847.8	7 902.1	117.4	100.7
Цэвэр экспорт	- 974.9	- 2 883.4	- 3 711.6	- 3 517.8	-	-

Эцсийн ашиглалтын аргаар, зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ 11.7 хувиар өсөхөд эцсийн хэрэглээ 1256.5 тэрбум төг буюу 14.3 хувиар, хөрөнгийн нийт хуримтлал 54.3 тэрбум төг буюу 0.7 хувиар өссөн нь нөлөөллөө.

Зураг 7. ДНБ-ий бодит өсөлтөд бүрэлдэхүүн хэсгийн оролцоо



Эцсийн ашиглалтын аргаар, зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий 11.7 хувийн өсөлтийн 9.7 пунктийг эцсийн хэрэглээ, 0.4 пунктийг хөрөнгийн нийт хуримтлал, 1.5 пунктийг цэвэр экспорт бүрдүүлжээ.

ГУРАВ. ОРЛОГЫН АРГААР ТООЦСОН ДНБ-ИЙ ГҮЙЦЭТГЭЛ

ДНБ-ий орлогын арга анхдагч орлогуудын нийлбэр буюу бараа, үйлчилгээний дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээнээс бий болсон ашиг болон орлогоос бүрдэнэ.

Орлогын аргаар тооцсон ДНБ оны үнээр 2013 онд 19118.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос цалин, түүнтэй адилтгах орлогын хэмжээ 14.4 хувь, үйлдвэрлэл, импортын цэвэр татвар 21.9 хувь, цэвэр ашиг, холимог орлого 13.5 хувь, үндсэн хөрөнгийн хэрэглээ 11.8 хувиар нэмэгдлээ.


Хүснэгт 14. ДНБ, орлогын бүрэлдэхүүн хэсгээр, тэрбум төг

	2010	2011	2012	2013	$\frac{2013}{2012}$ %
ДНБ	9 756.6	13 173.8	16 688.4	19 118.0	114.6
Цалин, түүнтэй адилтгах орлого	2 198.2	3 150.1	4 393.9	5 024.6	114.4
Үндсэн хөрөнгийн хэрэглээ	686.1	798.4	1 086.7	1 214.6	111.8
Үйлдвэрлэл, импортын цэвэр татвар	1 040.4	1 688.8	1 880.6	2 291.7	121.9
Ашиг/холимог орлого, цэвэр	5 831.9	7 536.4	9 327.3	10 587.2	113.5
ДНБ	100.0	100.0	100.0	100.0	
Цалин, түүнтэй адилтгах орлого	22.5	23.9	26.3	26.3	
Үндсэн хөрөнгийн хэрэглээ	7.0	6.1	6.5	6.4	
Үйлдвэрлэл, импортын цэвэр татвар	10.7	12.8	11.3	12.0	
Ашиг/холимог орлого, цэвэр	59.8	57.2	55.9	55.4	

Ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлого нь ДНБ-ий орлогын 2 дахь том бүрэлдэхүүн бөгөөд 2013 оны гүйцэтгэлээр ДНБ-ий 27.8 хувийг эзэлж байна.

Үйл ажиллагааны ашиг, холимог орлого ДНБ-ий орлогын томоохон бүрэлдэхүүн хэсэг бөгөөд 2013 оны гүйцэтгэлээр ДНБ-д 55.4 хувийг эзэлж байна.

Зураг 8. Ажиллагчдын цалин, ашиг, холимог орлогын ДНБ-д эзлэх хувь



ДӨРӨВ. ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО, ҮНДЭСНИЙ ЭЗЭМШЛИЙН ОРЛОГО

Үндэсний нийт орлого (ҮНО) гэдэг нь тухайн улсын эдийн засгийн харьяатгуудын шинээр бий болгосон нэмэгдсэн өртөг юм. ҮНО-ыг тооцохдоо эдийн засгийн харьяатын зарчимд тулгуурлах буюу ДНБ-ий гүйцэтгэл дээр харьяат болон харьяат бусын хооронд хийгдсэн дараах 2 төрлийн ажил гүйлгээний цэвэр орлогын хэмжээг нэмнэ. Үүнд, а. харьяат бус ажиллагчдад төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, б. хөрөнгө оруулалтын орлого буюу харьяат, харьяат бусын хооронд харилцан шилжүүлсэн ногдол ашиг, хүүгийн орлого орно.

Үндэсний нийт эзэмшлийн орлого (ҮНЭО) нь харьяатын зарцуулах, хадгалах боломжтой орлого юм. ҮНЭО-ыг тооцохдоо ҮНО-ын гүйцэтгэл дээр харьяат болон харьяат бусын хооронд хийгдсэн цэвэр шилжүүлгийг нэмж тооцно.

ҮНО 2013 оны гүйцэтгэлээр оны үнээр 18035.1 тэрбум төгрөгт хүрч, 2012 оныхоос 17.1 хувиар өслөө. ҮНО ДНБ-ий гүйцэтгэлээс 1082.9 тэрбум төгрөгөөр бага дүнтэй байна.


Хүснэгт 15. ДНБ, ҮНО, ҮНЭО оны үнээр, тэрбум төг

	2010	2011	2012	2013	$\frac{2013}{2012} \%$
ДНБ	9 756.6	13 173.8	16 688.4	19 118.0	114.6
Гадаад эдийн засгаас орж ирсэн цэвэр орлого	- 812.0	-1 067.2	-1 288.8	-1 082.9	84.0
Ажиллагчдын цалин, цэвэр	- 43.7	- 146.0	- 331.0	- 285.2	86.2
хүлээн авсан цалин (+)	24.8	38.1	46.4	69.9	150.7
төлсөн цалин (-)	68.6	184.1	377.4	355.1	94.1
Хөрөнгө оруулалтын орлого, цэвэр	- 768.3	- 921.2	- 957.9	- 797.7	83.3
хөрөнгө оруулалтын орлого (+)	14.4	17.2	31.3	9.1	29.2

хөрөнгө оруулалтын зардал (-)	782.7	938.4	989.2	806.8	81.6
ҮНО	8 944.6	12 106.5	15 399.6	18 035.1	117.1
Гадаад эдийн засгаас хүлээн авсан цэвэр шилжүүлэг	253.6	301.4	325.4	218.0	67.0
Засгийн газрын шилжүүлэг, цэвэр	44.6	22.4	49.7	45.3	91.2
хүлээн авсан шилжүүлэг (+)	47.5	35.9	55.6	52.3	94.1
шилжүүлсэн шилжүүлэг (-)	2.9	13.5	5.9	7.0	118.8
Ажиллагчдын гуйвуулга, цэвэр	175.4	74.0	55.7	36.2	65.0
хүлээн авсан гуйвуулга (+)	336.2	315.5	389.1	320.2	82.3
шилжүүлсэн гуйвуулга (-)	160.7	241.5	333.4	284.0	85.2
Торгуулийн орлого	33.5	204.9	220.1	136.5	62.0
хүлээн авсан орлого (+)	35.8	221.1	237.5	151.9	64.0
шилжүүлсэн орлого (-)	2.4	16.2	17.4	15.4	88.8
ҮНЭО	9 198.2	12 407.9	15 725.0	18 253.0	116.1

Үндэсний нийт эзэмшлийн орлого нь 2013 оны гүйцэтгэлээр, оны үнээр 18 253.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 16.1 хувиар өссөн байна.

Зураг 9. ДНБ, ҮНО, ҮНЭО, оны үнээр, тэрбум төг




ТАВ. НЭГ ХҮНД НОГДОХ ДНБ, ҮНО

5.1 Нэг хүнд ногдох ДНБ, ҮНО-ын үзүүлэлтүүд

Нэг хүнд ногдох ДНБ 2013 онд оны үнээр 6594.7 мян.төг, ҮНО 6221.1 мян.төгрөгт хүрч, өмнөх оныхоос нэг хүнд ногдох ДНБ 12.2 хувь, ҮНО 14.7 хувиар нэмэгдлээ. Дэлхийн банкны атласын аргаар тооцсон нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2013 онд оны үнээр 4579 ам.доллар болж, 2012 оныхоос 640 ам.доллар буюу 16.2 хувиар өсөж, нэг хүнд ногдох ҮНО оны үнээр 638 ам.доллар буюу 17.6 хувиар өсөж 4273 ам.долларт хүрлээ (Хавсралт 4).

Зураг 10. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, мян.төг



Нэг хүнд ногдох ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 4950.0 мян.төгрөгт хүрч, 2012 оныхоос 9.4 хувиар нэмэгдсэн байна.

5.2 Нэг хүнд ногдох ҮНО, олон улстай харьцуулсан байдал

Дэлхийн улс орнуудын хөгжлийн түвшинг хооронд нь харьцуулах стандарт үзүүлэлт бол нэг хүнд ногдох ҮНО юм.

Хүснэгт 16. Нэг хүнд ногдох ҮНО, бүс, улс орноор
(Дэлхийн банкны атласын аргаар, оны үнээр, ам.доллар)

Улс болон бүс	2010	2011	2012	2013	2013/2012%
Дэлхий	9 237	9 696	10 235	10 564	103.2
Бага орлоготой	538	575	620	664	107.1
Дунд орлоготой	3 540	3 928	4 402	4 721	107.2
- дунджаас доогуур орлоготой	1 595	1 759	1 969	2 068	105.0
- дунджаас дээгүүр орлоготой	5 562	6 199	6 968	7 540	108.2
Бага болон дунд орлоготой	3 116	3 449	3 857	4 131	107.1
- Зүүн Ази, Номхон далайн орнууд	3 696	4 226	4 904	5 536	112.9
- Европ, Төв Азийн орнууд	6 069	6 349	6 693	7 086	105.9
- Латин америк, Карибийн орнууд	7 652	8 325	9 071	9 314	102.7
- Өмнөд Азийн орнууд	1 197	1 337	1 437	1 474	102.6
- Саб Сахарийн орнууд	1 230	1 349	1 559	1 624	104.2
Өндөр орлоготой орнууд	35 921	37 139	38 533	39 312	102.0
- Евро бүсийн орнууд	38 544	38 819	38 133	38 333	100.5
Монгол*	2 265	2 786	3 635	4 273	117.6
ОХУ	10 010	10 820	12 740	13 860	108.8
БНХАУ	4 240	4 900	5 720	6 560	114.7

Эх сурвалж: www.worldbank.org, 2014 оны тооцоо

*ҮСХ-ны тооцоо

Дэлхийн банкнаас гаргадаг энэхүү үзүүлэлтэд манай улсыг дунд орлоготой орны дунджаас доогуур орлоготой бүлэгт хамааруулан авч үзсэн байна. Энэ бүлэг дэх орнуудын нэг хүнд ногдох ҮНО-ын дундаж 2013 оны байдлаар 2068 ам.доллар байгаа бол манай улсын нэг хүнд ногдох ҮНО 4273 ам.доллар байна. Хөрш орнуудтай харьцуулахад нэг хүнд ногдох ҮНО-ын хэмжээгээр ОХУ-аас 3.2 дахин, БНХАУ-аас 1.5 дахин бага байна. Нэг хүнд ногдох ҮНО-ын 2013 оны жилийн өсөлтөөрөө Монгол улс тэргүүлж байна. Дэлхийн өсөлт 3.2 хувь, дунд орлоготой орнуудынх 7.2 хувь, ОХУ-ынх 8.8 хувь, БНХАУ-ынх 14.7 хувь, Монгол улсынх 17.6 хувь байна.

АХБ-наас гаргадаг “Asian Development Outlook” судалгааны тайланд манай орны эдийн засгийн өсөлтөд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь уул уурхайтай холбоотой хөрөнгө оруулалт болон үйлдвэрлэлт бөгөөд цаашид уул уулхайтай холбоотой барилга болон үйлчилгээний үйл ажиллагаанд өндөр өсөлт гарна гэж дүгнэсэн байна. Тус байгууллага манай орны эдийн засгийн өсөлт 2014 онд 14.0 хувь өсөхөөр тооцоолсон байна.

ЗУРГАА. ДАЛД ЭДИЙН ЗАСАГ

Үндэсний тооцоонд хамрагдаагүй нуугдмал, хууль бус, албан бус үйл ажиллагаа, өөртөө зориулсан өрхийн хэрэглээний үйлдвэрлэл болон мэдээллийг бүрэн цуглуулж чадахгүй байгаагаас шалтгаалан албан ёсны мэдээллээс орхигддог үйл ажиллагааг нийтэд нь далд үйл ажиллагаа гэж нэрлэдэг бөгөөд тэдгээрийг үндэсний тооцоонд хамруулахыг далд эдийн засаг (ДЭЗ)-ийг тооцох гэж ойлгож тодорхойлдог.

Далд эдийн засгийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан дараах 7 талбарыг (N1-N7) авч үздэг.

N1. Бүртгэгдээгүй үйлдвэрлэгчид: Татвар, НДШ төлөхөөс зайлсхийж, бүртгүүлээгүй үйлдвэрлэгчид

N2. Хууль бус үйлдвэрлэгчид: Биеэ үнэлэх, хулгайлсан зүйлс борлуулах, мансууруулах бодис худалдах, үйлдвэрлэх, тээвэрлэх, барааг хууль бусаар хил давуулах, зөвшөөрөлгүй хуулбарлан борлуулах, мөрийтэй тоглоом зэрэг үйл ажиллагаа хамаарна.

N3. Бүртгүүлэх шаардлагагүй үйлдвэрлэгчид: Өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэл явуулж байгаа болон хувьдаа орон сууц барих, засварлах үйл ажиллагаа орно.

N4. Судалгаанд хамрагдаагүй, бүртгэлтэй хуулийн этгээд: Хуулийн этгээд нь бүртгэгдсэн хэрнээ БРС болон ААН-ийн судалгаанд хамрагдаагүй, орхигдсон, түүнчлэн БРС-д бүртгэгдээгүй, үзүүлэлтүүд нь шинэчлэгдээгүй буюу буруу байгаа хуулийн этгээд энэ талбарт хамарна.

N5. Судалгаанд хамрагдаагүй бизнес эрхлэгч: БРС-д хамрагдаагүй бизнес эрхлэгчид /БРС-д зарим төрлийн бизнес эрхлэгчдийг бүртгээгүй байдаг/, чөлөөт уран бүтээлч, зохиолч, тамирчид зэрэг бизнес эрхлэгчид хамаарна.

N6. Мэдээллийг буруу өгсөн үйлдвэрлэгчид: Орлогын татвар болон НӨАТ, НДШ төлөхөөс зайлсхийхийн тулд орлогоо дутуу мэдээлэх эсвэл зардлаа илүү тайлагнадаг үйлдвэрлэгчдийг энд хамруулна.

N7. Бусад

Хүснэгт 17. 2010-2013 оны далд эдийн засгийн нэмэгдэл өртөг, талбараар, сая төг

Он	Далд эдийн засгийн талбар					Нийт дүн
	N1	N2	N3	N5	N6	
2010	395.0	27.2	11.0	283.5	615.4	1 332.1
2011	597.6	37.7	16.6	427.9	629.6	1 709.4
2012	630.9	51.1	16.0	470.9	664.6	1 833.5
2013	699.6	74.0	15.9	523.7	926.1	2 239.4

Хүснэгт 18. 2010-2013 оны далд эдийн засгийн нийт нэмэгдэл өртөгт салбаруудын эзлэх хувь

Салбар	2010	2011	2012	2013
Хөдөө аж ахуй	0.6	0.8	0.8	0.7
Уул уурхай, олборлолт	22.9	11.0	9.3	12.5
Боловсруулах үйлдвэр	6.3	7.1	5.8	5.3
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	0.1	0.2	0.2	0.3
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	0.2	0.1	0.1	0.1
Барилга	6.2	10.1	9.3	9.1
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	39.7	44.8	47.0	43.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	14.0	13.3	15.2	14.6
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	2.1	2.4	2.7	2.6
Мэдээлэл, холбоо	0.5	0.8	0.8	0.8
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0.9	0.7	0.7	1.1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.4	0.5	0.4	0.5
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.3	1.9	1.8	2.3
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.4	0.9	0.7	1.4
Боловсрол	0.6	0.6	0.5	0.7
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	0.3	0.3	0.3	0.3
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.3	0.3	0.3	0.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2.7	3.9	3.9	4.2
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.3	0.2	0.2	0.0
Нийт дүн	100.0	100.0	100.0	100.0

Хүснэгт 19. 2010-2013 оны далд эдийн засгийн нийт нэмэгдэл өртөгт талбаруудын эзлэх хувь

Он	Далд эдийн засгийн талбар					Нийт дүн
	N1	N2	N3	N5	N6	
2010	29.7	2.0	0.8	21.3	46.2	100.0
2011	35.0	2.2	1.0	25.0	36.8	100.0
2012	34.4	2.8	0.9	25.7	36.2	100.0
2013	31.2	3.3	0.7	23.4	41.4	100.0

Дүгнэлт

2010 оны гүйцэтгэлд суурилж байгуулсан нөөц ашиглалтын хүснэгтийн үр дүнгээр тодотгож тооцоолсон ДНБ-ий бодит хэмжээ 2012 онд 12.3 хувийн өсөлттэй гарч байсан бол 2013 онд 11.6 хувийн өсөлттэй гарлаа.

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ оны үнээр 2013 онд 19118.0 тэрбум төгрөгт хүрч, 2012 оныхоос 2429.6 тэрбум төгрөг буюу 14.6 хувиар нэмэгдлээ.

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ 2010 оны зэрэгцүүлэх үнээр өмнөх оныхоос 11.6 хувиар өсөж, 14350.1 тэрбум төгрөгт хүрлээ. ДНБ-ий бодит өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 266.6 тэрбум төг буюу 11.5 хувь, уул уурхай, олборлох салбар 475.2 тэрбум төг буюу 19.4 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 85.0 тэрбум төг буюу 10.9 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбар 127.9 тэрбум төг буюу 6.5 хувь, барилгын салбар 46.4 тэрбум төг буюу 8.2 хувь, санхүү, даатгалын салбар 168.3 тэрбум төг буюу 33.1 хувь өссөн нь голлон нөлөөлжээ.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ оны үнээр 2013 онд 19326.2 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 2637.8 тэрбум төгрөг буюу 15.8 хувиар өслөө.

Нэг хүнд ногдох ДНБ 2013 онд оны үнээр 6594.7 мянган төгрөгт хүрч, өмнөх оныхоос 12.2 хувиар нэмэгджээ. Дэлхийн банкны атласын аргаар тооцсон нэг хүнд ногдох ДНБ оны үнээр 4579 ам.доллар болж, өмнөх оныхоос 640 ам.доллар буюу 16.2 хувиар нэмэгдсэн байна.

Хавсралт 1. ДНБ, оны үнээр, тэрбум төг

	2010	2011	2012	2013
ДНБ	9 756.6	13 173.8	16 688.4	19 118.0
Өөрчлөлт, *%		35.0	26.7	14.6
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1 144.7	1 357.9	1 878.8	2 603.6
Өөрчлөлт, %		18.6	38.4	38.6
Уул уурхай, олборлолт	2 102.2	2 536.2	2 742.8	2 965.6
Өөрчлөлт, %		20.6	8.1	8.1
Боловсруулах үйлдвэрлэл	664.8	931.4	1 248.7	1 708.3
Өөрчлөлт, %		40.1	34.1	36.8
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	190.2	212.4	233.9	270.5
Өөрчлөлт, %		11.7	10.1	15.6
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	31.2	44.9	72.5	77.5
Өөрчлөлт, %		44.2	61.5	6.9
Барилга	250.2	402.8	837.5	978.9
Өөрчлөлт, %		61.0	107.9	16.9
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1 199.0	1 973.3	2 231.1	2 123.9
Өөрчлөлт, %		64.6	13.1	-4.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	677.9	802.9	894.4	835.6
Өөрчлөлт, %		18.4	11.4	-6.6
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	52.6	94.3	186.2	201.6
Өөрчлөлт, %		79.3	97.5	8.3
Мэдээлэл, холбоо	255.7	290.3	379.6	402.4
Өөрчлөлт, %		13.5	30.8	6.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	239.6	381.1	583.5	797.5
Өөрчлөлт, %		59.1	53.1	36.7
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	687.7	884.2	957.3	1069.9
Өөрчлөлт, %		28.6	8.3	11.8
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	132.3	216.2	424.2	437.6
Өөрчлөлт, %		63.4	96.2	3.2

Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	81.1	71.2	177.6	193.2
Өөрчлөлт, %		-12.2	149.4	8.8
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	425.4	515.3	699.1	788.8
Өөрчлөлт, %		21.1	35.7	12.8
Боловсрол	379.9	503.1	744.9	854.5
Өөрчлөлт, %		32.4	48.1	14.7
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	167.2	193.2	316.9	359.1
Өөрчлөлт, %		15.6	64.0	13.3
Урлаг, үзвэр, тоглоом наадам	32.0	39.5	87.0	84.1
Өөрчлөлт, %		23.4	120.3	-3.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	44.4	67.2	137.8	145.0
Өөрчлөлт, %		51.4	105.1	5.2
Бүтээгдэхүүний цэвэр татвар	998.4	1 656.3	1 854.4	2 220.1
Өөрчлөлт, %		65.9	12.0	19.7

*жилийн өөрчлөлт, өмнөх оны мөн үе=100, %

Хавсралт 2. ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг

	2010	2011	2012	2013
ДНБ	9 756.6	11 443.6	12 853.4	14 350.1
Өөрчлөлт, %		17.3	12.3	11.6
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1 144.7	1 141.1	1 381.3	1 647.9
Өөрчлөлт, %		-0.3	21.0	19.3
Уул уурхай, олборлолт	2 102.2	2 263.7	2 452.2	2 927.4
Өөрчлөлт, %		7.7	8.3	19.4
Боловсруулах үйлдвэрлэл	664.8	717.1	779.7	864.7
Өөрчлөлт, %		7.9	8.7	10.9
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	190.2	203.1	213.2	224.8
Өөрчлөлт, %		6.8	5.0	5.4
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	31.2	31.9	31.5	32.6
Өөрчлөлт, %		2.2	-1.3	3.5
Барилга	250.2	307.0	568.8	615.2
Өөрчлөлт, %		22.7	85.3	8.2
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1 199.0	1 755.4	1 965.6	2 093.5
Өөрчлөлт, %		46.4	12.0	6.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	677.9	779.9	843.2	828.5
Өөрчлөлт, %		15.0	8.1	-1.7
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	52.6	66.7	75.8	80.5
Өөрчлөлт, %		26.8	13.6	6.2
Мэдээлэл, холбоо	255.7	270.5	314.3	355.8
Өөрчлөлт, %		5.8	16.2	13.2
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	239.6	357.4	509.0	677.3
Өөрчлөлт, %		49.2	42.4	33.1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	687.7	704.0	718.0	733.4
Өөрчлөлт, %		2.4	2.0	2.1

Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	132.3	133.8	135.3	141.9
Өөрчлөлт, %		1.1	1.1	4.9
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	81.1	82.6	84.3	83.9
Өөрчлөлт, %		1.8	2.1	-0.5
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	425.4	387.5	408.0	429.1
Өөрчлөлт, %		-8.9	5.3	5.2
Боловсрол	379.9	383.0	387.3	392.4
Өөрчлөлт, %		0.8	1.1	1.3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	167.2	151.6	154.9	162.9
Өөрчлөлт, %		-9.3	2.2	5.2
Урлаг, үзвэр, тоглоом наадам	32.0	28.3	28.9	30.3
Өөрчлөлт, %		-11.6	2.1	4.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	44.4	52.4	57.6	57.8
Өөрчлөлт, %		18.0	9.9	0.3
Бүтээгдэхүүний цэвэр татвар	998.4	1626.5	1744.4	1970.2
Өөрчлөлт, %		62.9	7.2	12.9

Хавсралт 3. Макро-эдийн засгийн зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2010	2011	2012	2013
А. Бодит сектор				
ДНБ(Ү),оны үнээр, тэрбум төг	9 756.6	13 173.8	16 688.4	19 118.0
ДНБ(Э),оны үнээр, тэрбум төг	9 756.6	13 173.8	16 688.4	19 326.2
ДНБ(Ү)-ий бодит өсөлт		17.3	12.3	11.6
ДНБ(Э)-ий бодит өсөлт		17.5	12.5	11.7
Хөрөнгө оруулалт (ДНБ*-д эзлэх хувь)	39.4	63.7	56.3	32.5
Гадаадын хөрөнгө оруулалт (ДНБ*-д эзлэх хувь)	25.0	45.3	38.7	18.1
Б. Санхүүгийн сектор				
Төсвийн нийт орлого / ДНБ	32.0	32.1	29.1	31.1
Төсвийн нийт зарлага / ДНБ	31.6	37.9	35.9	32.2
Төсвийн нийт тэнцэл / ДНБ	0.4	- 5.8	- 6.8	- 1.2
Засгийн газрын гадаад өр, сая ам.доллар**	1 767.0	1 927.2	4 264.1	4 256.3
Татварын орлого / ДНБ	27.6	27.8	25.0	26.5
Урсгал зардал / ДНБ	23.1	24.6	26.4	23.8
Хөрөнгийн зардал / ДНБ	6.1	9.7	9.1	7.8
Эргэж төлөгдөх цэвэр зээл /ДНБ	2.4	3.6	0.4	0.6
В. Мөнгөний сектор				
МУ-ын нийт гадаад өр, сая ам.доллар**	3 996.8	9 621.6	15 384.5	18 920.6
Хувийн хэвшлийн гадаад өр сая ам.доллар**	1 965.3	7 426.7	10 706.5	13 598.9
M2 /ДНБ	48.0	48.7	45.6	49.5
Ам.долларын жилийн дундаж ханш (1 ам.доллар = төг)	1 356.4	1 265.5	1 359.4	1 525.7

Г. Гадаад сектор

Экспорт, бодит өсөлт	18.2	8.3	13.7
Импорт, бодит өсөлт	49.5	15.4	6.3
Экспорт (ДНБ*-д эзлэх хувь)	46.7	40.9	34.9
Импорт (ДНБ*-д эзлэх хувь)	56.7	62.8	57.2
Цэвэр экспорт (ДНБ*-д эзлэх хувь)	10.0	21.9	22.2

Д. Үнэ

Инфляцийн жилийн дундаж түвшин	10.1	9.2	14.3	10.5
ДНБ*-ий дефлятор	100.0	115.1	129.8	133.2
ДНБ*-ий дефляторын өсөлт	15.1	12.8	2.6	

Е. Ажиллагчид

Хүн ам (жилийн дундаж), мян.хүн	2 738.6	2 786.3	2 839.7	2 899.0
Ажиллагчид, оны эцэст	1 033.7	1 037.7	1 056.4	1 103.6

*ДНБ эцсийн ашиглалтын аргаар

** эх үүсвэр: Монголбанк "МУ-ын гадаад секторын тойм, 2013"

*** Тус үзүүлэлтийг ам.долларын жилийн дундаж ханш ашиглан, төгрөгт шилжүүлэн тооцсон болно.

Хавсралт 4. Нэг хүнд ногдох ДНБ, ҮНО

Нэг хүнд ногдох ДНБ, ҮНО

	2010	2011	2012	2013	$\frac{2013}{2012}$ %
ДНБ, оны үнээр, мян.төг	3 562.6	4 728.0	5 876.8	6 594.7	112.2
ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, мян.төг	3 562.6	4 107.1	4 526.3	4 950.0	109.4
ДНБ, оны үнээр, ам.доллар	2 471	3 031	3 939	4 579	116.2
ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, ам.доллар	2 471	2 639	3 045	3 214	105.6
ҮНО, оны үнээр, мян.төг	3 266.1	4 345.0	5 422.9	6 221.1	114.7
ҮНО, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, мян.төг	3 266.1	3 774.3	4 176.8	4 669.6	111.8
ҮНО, оны үнээр, ам.доллар	2265	2786	3635	4273	117.6
ҮНО, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, ам.доллар	3 562.6	4 728.0	5 876.8	6 594.7	99.6

Хавсралт 5. ДНБ, ҮНО, ҮНЭО, оны үнээр, сая төг

	2010	2011	2012	2013
Дотоодын нийт бүтээгдэхүүн	9 756.6	13 173.8	16 688.4	19 118.0
Гадаад эдийн засгаас хүлээн авсан анхдагч орлого	39.2	55.3	77.7	79.1
Ажиллагчдын цалин	24.8	38.1	46.4	69.9
Зээлийн хүү	14.4	17.2	31.3	9.1
Гадаад эдийн засагт төлсөн анхдагч орлого	851.2	1 122.6	1 366.6	1 162.0
Ажиллагчдын цалин	68.6	184.1	377.4	355.1
Зээлийн хүү	782.7	938.4	989.2	806.8

Үндэсний нийт орлого	8 944.6	12 106.5	15 399.6	18 035.1
өөрчлөлт, %		35.4	27.2	17.1
Гадаад эдийн засгаас хүлээн авсан шилжүүлэг	419.5	572.5	682.1	524.4
Засгийн газрын шилжүүлэг	47.5	35.9	55.6	52.3
Ажиллагчдын гуйвуулга	336.2	315.5	389.1	320.2
Бусад шилжүүлэг	35.8	221.1	237.5	151.9
Гадаад эдийн засагт шилжүүлсэн шилжүүлэг	166.0	271.1	356.7	306.5
Засгийн газрын шилжүүлэг	2.9	13.5	5.9	7
Ажиллагчдын гуйвуулга	160.7	241.5	333.4	284
Бусад шилжүүлэг	2.4	16.2	17.4	15.4
Үндэсний нийт эзэмшлийн орлого	9 198.2	12 407.9	15 725.0	18 253.0
өөрчлөлт, %		34.9	26.7	16.1
ҮНО, 2010 оны зэрэгцүүлэх үнээр	8 944.6	10 516.5	11 860.7	13 537.3
өөрчлөлт, %		17.6	12.8	14.1